



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 25-ны өдөр

Дугаар А/56

Эрдэнэт

“Амин дэм хуваарилах тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 78-р тогтоол Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 05 сарын 19-ны өдрийн “Нэмэлт аминдэмээр хангахад дэмжлэг үзүүлэх тухай” А/280 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн эхчүүдэд зориулсан нэмэлт аминдэмийг олгож, тайлан мэдээг нэгтгэх журмыг нэгдүгээр, аминдэмийн зарцуулалтад хяналт тавих багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, аминдэм олгосон эхчүүдийн бүртгэлийн хуудсыг гуравдугаар, нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд түгээх амин дэмийн хуваарилалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Санхүүжилтийг эрх зүйн хүрээнд шийдвэрлэж, зарцуулахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн эхчүүдийг аминдэмжүүлэлтэд хамруулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Хоол тэжээл хүнсний аюулгүй байдал хариуцсан ажилтан /Т. Байгаль/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г. Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 05 дүгээр сарын
25-ний өдрийн 418 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд зориулсан нэмэлт аминдэмийн
зарцуулалтад хяналт тавих багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч : Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон ахмад настны
асуудал хариуцсан ажилтан

Гишүүд:

Хоол тэжээл хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан

Эмийн чанар аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн

Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдийг аминдэмжүүлэлтэнд хамруулах журам

Энэхүү журам нь Сум өрхийн эрүүл мэндийн төв өртөмтгий бүлгийн жирэмсэн эхийг хянах кабинетийн хяналтанд бүртгэгдсэн, нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдийг олон найрлагт аминдэмээр үнэ төлбөргүй хангах харилцааг зохицуулна .

1. Эрүүл мэндийн газрын даргын дээрх тушаалын дөрөвдүгээр хавсралтад заагдсан хуваарийн дагуу Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд Орхон монос ЭХНБ-аас авна.
2. Орхон Монос ЭХНБ нь аминдэмийн хуваарь гарснаас хойш 7 хоногт багтааж, СӨЭМТ-үүдэд аминдэмийг түгээж, баримтжуулсан хуудас, Е- баримтыг Эрүүл мэндийн газрын ЭБХЧАБХМэргэжилтэн /О.Анхбаяр/-аар шалгуулж, Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодогчид хүлээлгэн өгнө.
3. Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодогчид ЭХНБ-аас ирүүлсэн нэхэмжлэл, эмийн сангийн аминдэм түгээсэн баримтыг үндэслэн мөнгөн гүйлгээг хийнэ.
4. Эмч нар өөрийн харъялалын нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдээс нийгэм биологийн болон эх барихын ужиг дурдатгалтай эхчүүдийг сонгон аминдэмжүүлэлтэнд хамруулна. Үүнд:
 - Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн оюутан болон хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн ээжүүд, хоол тэжээлийн архаг дутагдалтай жирэмсэн болон хөхүүл ээжүүд / БЖИ18,5 аас бага /, цус багадалттай жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд олгоно
 - 15- аас өмнөх насанд жирэмсэлсэн , хэт намхан 140 см- ээс бага өндөртэй, ихэр жирэмсэн, хэт ойрхон жирэмсэлсэн , ихэсийн дутмагшил, ургийн өсөлтийн саатал оношлогдсон жирэмсэн эхчүүдэд олгоно
5. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн эхчүүдэд бэлдмэлийг олгохдоо 1 эхэд 30 ширхгээр олгож 30 өдрийн туршид уулгана.
6. СӨЭМТ, ӨБЖЭХ-Кабинетийн эмч нар зорилтот бүлгийн эхийг сонгож, оношийн үндэслэлийг гаргаж, арга зүйч сувилагчид илгээж, арга зүйч нар эмийг түгээж, цус багадалттай эхийн шинжилгээг хавсаргаж, баримтжуулах ажлыг хариуцна.
7. Өрхийн эрүүл мэндийн төвүүд төмөр агуулсан амин дэмийг зааврын хамт эхчүүдэд олгож гарын үсэг зуруулж баталгаажуулсан бүртгэлийн хуудсыг дараа улирлын 2 дахь сард багтаан ЭМГ-ын ХТХАБАХМэргэжилтэнд ирүүлнэ.
8. СӨЭМТ, ӨБЖЭХКабинетийн эмч нар эхэд аминдэм олгосны дараа 45-60 хоногийн дараа давтан шинжилгээнд хамруулж, эмчилгээний үр дүнг тооцож, арга зүйч сувилагч

нэгдсэн тандалын хуудсанд тэмдэглэн мэдээг эрүүл мэндийн газрын хоол тэжээл хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтанд ирүүлнэ.

9. Тухайн улирлын аминдэмийг авахдаа өмнөх улиралд олгосон аминдэмийн үр дүнгийн судалгааг ирүүлсэн байна.
10. Аминдэмийн зарцуулалтанд хяналт хийх баг нь хагас жил тутамд СӨЭМТ, ЖӨБЭХК-аар зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхэд олгосон аминдэмийн чанар хүртээмж, хэрэглээний үр дүнг үнэлэх хяналтыг зохион байгуулж, тайлагнана.

Эрүүл мэндийн газрын даргын
 2021 оны ᠘ дүгээр сарын
 ᠒᠘-ний өдрийн А/᠒᠗ дугаар
 тушаалын гурадугаар хавсралт

НИЙГМИЙН ХАЛАМЖ НЭН ШААРДЛАГАТАЙ ЭХЧҮҮДЭД АМИНДЭМ ОЛГОСОН БҮРТГЭЛИЙН ХУУДАС

1	Овог нэр	Регистер-ийн дугаар	Гэрийн хаяг Холбоо барих утас	Хариуц сан эмчийн нэр	Үндсэн онош Загвар / DS:Gr X XX-XX нед	Өртөмтгий байдал				Гемоглобины хэмжээ		Олгосон он сар	Олгосон аминдэмийн тоо	Аминдэм хүлээн олгосон хүний гарын үсэг	Аминдэм хүлээн авсан хүний гарын үсэг
						Цус багадалт	Эх барихын ужиг датгалтай	Экстрагегитал өвчтэй	НХХШ бүлэг	Аминдэм хэрэглэхийн өмнө	Аминдэм хэрэглэсний дараа				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16

Бүртгэл хөтөлсөн: Сувилагч гарын үсэг / /
 Хянасан: Арга зүйч гарын үсэг / /

Эрүүл мэндийн газрын даргын
2021 оны 05 дүгээр сарын
25-ний өдрийн 11/6 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

Нийгмийн халамж нэн шаардлагатай эхчүүдэд түгээх аминдэмийн хуваарилалт

2020 оны 05 сарын 22

№	Өрхийн эмнэлгийн нэр	II-р улирал					III-р улирал			IV-р улирал			Эм түгээсэн он сар өдөр	Хүлээн авсан хүний нэр
		Нийт жирэмсэн эхийн тоо	Нийт цус багадалттай эхийн тоо	Аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн	Аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн	Аминдэм олгох эхийн тоо	1 эхэд олгох эмийн тоо	Нийт эмийн дүн		
1	Мэндцэцэн	258	16	15	30	450	15	30	450	15	30	450		
2	Анхны Оч	255	18	15	30	450	15	30	450	15	30	450		
3	Учралтбаяр	202	10	12	30	360	12	30	360	11	30	330		
4	Энхжинмандарваа	208	9	12	30	360	12	30	360	11	30	330		
5	Үйлсбадрах	210	6	11	30	330	11	30	330	10	30	300		
6	Мөнхийн гэгээ	190	5	9	30	270	9	30	270	8	30	240		
7	Нийцэл	193	7	9	30	270	9	30	270	8	30	240		
8	Мөнхсүндрэл	136	8	9	30	270	9	30	270	8	30	240		
9	Жаргалант сум	42	4	6	30	120	6	30	120	5	30	150		
Дүн		1694	83	98	270	2880	98	270	2880	91	270	2730		

Хуваарийг хийсэн: ХТХАБАХМ
Аминдэмийг түгээсэн: эм зүйч

Т. Байгаль